



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**Ундны ус, ариун цэврийн байгууламжтай
холбоотой хэрэгжүүлж буй төсөл
хөтөлбөрүүд, тэдгээрийн үр нөлөө
/“ТХЗ-2030”-ын 6.1/**

АУДИТЫН ТАЙЛАНГААС





Ундны ус, ариун цэврийн байгууламжтай холбоотой хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд, тэдгээрийн үр нөлөө /“ТХЗ-2030”-ын 6.1/



БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ ТОГТОЛЦОО БҮРДЭЭГҮЙ, УНДНЫ УС, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖТАЙ ХОЛБООТОЙ 1.9 ИХ НАЯД ТӨГРӨГИЙН ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН Ч БОДЛОГОД ГАРСАН ЭЭРЭГ ӨӨРЧЛӨЛТИЙН ҮР НӨЛӨӨГ ТООЦООГҮЙ БАЙНА.

Монгол Улс 2025 он гэхэд

Шаардлага хангасан ундны усны эх үүсвэр

85%



Шаардлага хангасан ариун цэврийн байгууламж эх үүсвэр

70%

Нийт сумдын 71 хувьд нь усны нөөц тогтоогдоогүй байна



Хүн амын ундны усны чанар, аюулгүй байдалд төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт, шалгалтыг 21 аймаг, 330 сумдад бүрэн хийгээгүй нь төсөв болон хүний нөөцийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалсан байна.




Тогтвортой хөгжлийн зорилго
2018 оны суурь



37%




62%



“Алсын хараа-2050” 2018 оны суурь




82.5%



69%



Нийт сумдын 77 хувь нь цэвэрлэх байгууламжгүй



Хуульд усны аюулгүй байдлын бодлогыг Байгаль орчны төв байгууллага хариуцна гэж заасан ч 2024 оны GLAAS судалгаанд ХББОСЯ-ыг УАЦЭА-гийн шийдвэр, хөтөлбөрийг тэргүүлэгчээр дурдсан нь бодлого хариуцах байгууллага тодорхойгүй болгож байна.





Ундны ус, ариун цэврийн байгууламжтай холбоотой хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд, тэдгээрийн үр нөлөө /“ТХЗ-2030”-ын 6.1/



Улсын төсвөөр

Улсын төсвийн хөрөнгөөр 2010-2025 онуудад 352.8 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 186 ТАХ хэрэгжүүлсэн.

Гадаад зээл тусламж

Гадаад зээл тусламжаар 2010-2025 онуудад 1,467.0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 8 ТАХ хэрэгжүүлсэн.



Аймаг, нийслэлийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрээр 2020-2024 онд нийт 148.2 тэрбум төгрөгөөр ундны усны болон ариун цэврийн барилга байгууламжтай холбоотой төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.



Нийслэлийн байгууллагууд ундны ус, ариун цэврийн төслүүд хэрэгжүүлж байгаа ч тэдгээрийн бодлогын зорилтод үзүүлэх нөлөөг дүгнэн тайлагнах, нэгдсэн статистик мэдээлэл бүрдүүлэх ажил дутуу байна.



Нийслэлийн хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилт болон усны чанарын шаардлага хангалтгүй байна.



Улаанбаатарын 17,742 худгийг шалгасан ч зарим цэгт тогтмол хяналт хийгдээгүй нь тогтоогдлоо. Мөн УСУГ-ын шугамын насжилт, лабораторийн хяналтын дүнг MNS 0900:2018 стандартад үнэлэхэд үл нийцэл гарсан.





Ундны ус, ариун цэврийн байгууламжтай холбоотой хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд, тэдгээрийн үр нөлөө /“ТХЗ-2030”-ын 6.1/



УСУГ-ын хариуцдаг Налайх, Дүнжингарав, Монос, Нисэх, Ханьн материал зэрэг бохир ус тээвэрлэх таван цэгт хяналт, зохицуулалт хангалтгүй байгаа нь төв цэвэрлэх байгууламжид стандартын шаардлага хангаагүй бохир ус нийлүүлэх эрсдэлийг бүрдүүлж байна.



УСУГ-тай гэрээтэй 468 ААН-аас ТЦБ-д нийлүүлж буй бохир усны бохирдол MNS 6561:2015 стандартаас 2.4–4.8 дахин өндөр байгаа нь механик цэвэрлэгээнд хэт ачаалал үүсгэж, биологийн цэвэрлэгээний процессыг хэвийн явуулах боломжгүй болгож байна.



Усны тухай хуулийн 11.1.4 болон холбогдох журмын дагуу усны эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг ИТХ-аар батлан, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх ёстой ч энэ үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.





ИТХ-аар батлуулагдаж, Хууль зүйн яаманд захиргааны хэм хэмжээний акт болгон бүртгэгдсэн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсийн мэдээллийг газрын нэгдмэл сангийн цахим системийн мэдээлэлтэй тулган шалгахад дараах зөрчил илэрлээ





Аудитын хээрийн судалгаагаар 8 аймаг, 9 суманд ажиллаж, мэргэжилтнүүдтэй уулзан ундны усны 12 сорьц авч, MNS ISO 5667-11 стандартаар хээрийн хэмжилт, MNS 0900:2018 стандартаар бактериологийн хоёр үзүүлэлтээр 24 цагийн түргэвчилсэн шинжилгээ хийв.

Уран болон Фтор ионы агуулга мг/л-г байршилудаар MNS900:2018 тай харьцуулав



Манган болон төмрийн ионы агуулгыг мг/л-г байршилудаар MNS900:2018 тай харьцуулав





Ундны ус, ариун цэврийн байгууламжтай холбоотой хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд, тэдгээрийн үр нөлөө /“ТХЗ-2030”-ын 6.1/



ДҮГНЭЛТ



1. Урт хугацааны бодлогын баримт бичигт хүн амыг эрүүл аюулгүй ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах зорилтын суурь үзүүлэлт “Эрүүл, аюулгүй ундны ус” гэсэн микробиологийн, химийн чанарын шалгуур тусгагдаагүй тул бодлогын зорилтын хэрэгжилт чанарын шалгуураар нийцэхгүй, ТХЗ 6.1, 6.2-ийн шаардлагыг хангахгүй байна.



2. Хүн амыг эрүүл, аюулгүй ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах чиг үүрэг бүхий төрийн захиргааны төв болон бусад байгууллагууд чиг үүргээ хэрэгжүүлэхдээ уялдаа холбоо хангалтгүй, тус тусдаа, салангид байдлаар бодлогыг хэрэгжүүлж байгаа нь хүний эрүүл мэндэд чиглэсэн цогц, үр дүнтэй бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж байна.



3. Төсвийн ерөнхийлөн захирагчдын хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд хүн амын ундны усны хүртээмж, чанар, ариун цэврийн нөхцөлд гарсан өөрчлөлт, ахиц дэвшлийг тогтмол хэмжих, хянах, тайлагнах механизм дутмаг, нарийвчилсан судалгаа хийгдээгүй, баримт материал бүрдээгүй байгаа нь бодлогын зорилго, зорилтын хэрэгжилтэд нөлөөллийг тооцох боломжгүй болгож байна.



4. Яамд, агентлаг, орон нутагт төрийн захиргааны байгууллагад ус болон ариутгал татуургын нарийн мэргэжлийн, мэргэшсэн боловсон хүчний хүрэлцээ муу байгаа нь ажлын байранд тавигдах мэргэжлийн ур чадвар, туршлагын шаардлагыг хангах ажилтан хомс, орон нутагт мэргэшсэн боловсон хүчин тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдээгүй, орон нутгийн онцлогт тохирсон хүний нөөцийн бодлого байхгүй зэрэг хүчин зүйлсээс шалтгаалж байна.



5. Нийт сумдын 29 хувьд усны нөөц тогтоосон байгаа нь хүн амыг баталгаат, хүрэлцээтэй ундны усаар тогтмол хангах нөхцөлийг бүрэн бүрдүүлээгүй байна.



6. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 474 дүгээр, 2021 оны 161 дүгээр тогтоол тус тус хэрэгжихгүй байна. Монгол Улсын засгийн газрын дээрх тогтоолд зааснаар Аймаг, сумын нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, инженерийн дэд бүтцийн барилга, байгууламжийн ашиглалт, үйлчилгээг зохион байгуулах ажлыг Засаг дарга нарт даалгасан байгаа нь улсын хэмжээний нэгдсэн бодлого хэрэгжихгүй байх нөхцөлийг бүрдүүлж, бодлогын зохицуулалт алдагдсан байна.



7. Ундны ус болон бохир усны чанарын хяналт шалгалтын мэдээллийг НЭМҮТ-ын tandalt.mn системд бүрэн оруулсан боловч усны мэдээллийн нэгдсэн системд холбогдох мэдээллийг бүрэн оруулаагүй, иргэдийг нээлттэй мэдээллээр тогтмол хангаагүй байна.



8. Ундны ус, ариун цэврийн байгууламжаас авах шинжилгээг улсын хэмжээнд бүрэн хамруулдаггүй, хяналт шалгалтыг хангалтгүй хийснээр Монгол Улсын хүн амын дунд бохир ус, ариун цэврийн байгууламжийн хангалтгүй байдал нь гэдэсний халдвар, дизентери зэрэг өвчлөлийн тархалт нэмэгдэж хөдөлмөрийн бүтээмж буурах, ялангуяа 5 хүртэлх насны хүүхдүүд тус өвчлөлд илүү өртөмтгий байдаг нь цэцэрлэг, сургууль завсардалт нэмэгдэх зэрэг сөрөг нөлөө үзүүлж байна.



9. Улсын хэмжээнд 2020-2024 онуудад улсын төсөв, гадаад зээл тусламжаар ундны ус, ариун цэврийн байгууламжтай холбоотой 1.9 их наяд төгрөг зарцуулсан ч, бодлогын зорилтод ямар үр нөлөө үзүүлсэн нь тодорхойгүй байна.



10. Нийслэл, аймаг, сумдын усан сан бүхий газрын усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн усны эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийг бүрэн тогтоогоогүй, холбогдох хууль, журам, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулаагүй байна. Мөн орон нутгийн мэргэжилтнүүдтэй хийсэн уулзалт, ярилцлагын явцад MNS 0900:2018 стандартын 6.3-д заасан “Төвлөрсөн ус хангамжийн усны чанар, аюулгүй байдлын хяналт шинжилгээ”-г аргачлалын дагуу бүрэн хийдэггүй, эрүүл ахуйн дүгнэлт гаргах үйл ажиллагаа аймаг, сумдын түвшинд хангалтгүй байгаа нь хүн ам эрүүл, аюулгүй ундны усаар бүрэн хангах ТХЗ 6.1 зорилт болон улсын хөгжлийн бодлогын зорилт биелэхгүй байх сөрөг үр дагавар үүсгэж байна.



ДҮГНЭЛТ



11. Нийслэл, аймаг, сумдын ус хангамжийн эх үүсвэрийг хамгаалалтад авсан нэгдсэн судалгаа, дүн мэдээ хангалтгүй, орон нутгийн төрийн байгууллагуудын уялдаа, холбоо сул, ИТХ-ын тогтоолоор батлуулж, Хууль зүйн яамны захиргааны хэм хэмжээний акт болж албажуулсан аймаг, сумдын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсийн мэдээллийг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд бүртгэхгүй байгаагаас, газар зохион байгуулалтын төлөвлөлт хийхдээ ундны усны эх үүсвэрийн хязгаарлалтын болон эрүүл ахуйн бүсэд иргэн, хуулийн этгээдэд газар олгох, барилга байгууламж барих зөвшөөрөл олгосон байна.



12. УСУГ-ын хариуцан ажиллуулдаг Улаанбаатар хотод бохир ус тээврээр зөөвөрлөн Налайх, Дунжингарав, Монос, Нисэх, Ханын материал гэсэн таван цэгт хяналт, зохицуулалт хангалтгүй байгаа нь төв цэвэрлэх байгууламжид стандартын шаардлага хангаагүй бохир ус нийлүүлэгдэх нөхцөлийг бүрдүүлж байна.



13. Улаанбаатар хотын хэмжээнд ус бохирдуулагч үйлдвэрүүдийн 70 хувь нь урьдчилан цэвэрлэх байгууламжгүй, хууль, стандартын шаардлага хангахгүй байгаа учир, ТЦБ-д ирж буй бохир усны бохирдлын агууламж нь MNS 6561:2015 стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс 2.4-4.8 дахин их байгаа нь механик цэвэрлэгээний хэсэгт хэт ачаалал үүсгэж, биологийн цэвэрлэгээний процесс хэвийн явагдах боломжгүй болгож байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газар Компакт гэрээгээр хүлээсэн үүргийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 53 дугаар тогтоол баталсан “Үйлдвэрийн хаягдал усыг урьдчилан цэвэрлэх төлөвлөгөө” бүрэн хэрэгжээгүйн улмаас шинэ Төв цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаанд хүндрэл учруулах нөхцөл бүрдүүлж байна.



14. Бохирдуулагч ангиллын үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч нарт төрийн захиргааны төв байгууллагаас үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохдоо үйл ажиллагаанаас гарах хаягдал бохир усны бохирдлыг бууруулах урьдчилан цэвэрлэх байгууламж, тоног төхөөрөмж суурилуулсан эсэхэд хяналтыг сайн хийдэггүй байна.



15. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн хөтөлбөрт ус, ариун цэврийн байгууламжийг зөв, зохистой ашиглах талаар тусгаагүй байна.



16. Улсын хэмжээнд сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих ажил хийгдэж байгаа ч, төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй сумдын сургууль, цэцэрлэгийн ариун цэврийн байгууламж улирлын нөлөөгөөр саатал үүсэж, шугам бөглөрөх, хөлдөх зэрэг хүндрэл гарч байна. Үүний улмаас уламжлалт, сайжруулсан нүхэн жорлон ашиглаж байгаа нь сурагчдын эрүүл ахуйд сөрөг нөлөө үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ашиглах ариун цэврийн байгууламж байхгүй нь хүүхэд бүрийг тэгш хүртээмжтэй, эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжид хамруулах ТХЗ 6.2-ын зорилтыг хангаагүй байна.



17. Монгол Улсад малчин өрхийн хэдэн хувийг эрүүл аюулгүй ундны усны эх үүсвэрээр хангах инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглахтай холбоотой эрх зүйн баримт бичиг байхгүй, бодлого тодорхойгүй байна.



18. Малчин өрх наад захын шаардлага хангасан эрүүл аюулгүй ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдахгүй байна.



ЗӨВЛӨМЖ

Засгийн газарт /Ерөнхий сайдад/:

1. Улсын хэмжээний эрүүл, аюулгүй ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах төрийн байгууллагуудын чиг үүргийн давхардсан болон орхигдсон байдалд дүн шинжилгээ хийж, бодлогын хэрэгжилтийг нэгдсэн тогтолцоонд оруулах арга хэмжээг зохион байгуулах.

2. Хүн амыг ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах талаар төрөөс баримталж буй бодлогын зорилтын суурь үзүүлэлтийг микробиологийн, химийн чанарын шалгуур үзүүлэлтийг тусгах, нэгтгэн тайлагнах, өөрчлөлтийг үнэлдэг байх нэгдсэн тогтолцоог бий болгох.

3. Дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулахдаа хүн амыг эрүүл, аюулгүй ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах зорилго, зорилтын шалгуур үзүүлэлтийг хэмжигдэхүйц, зорилтот түвшнийг бодитой тодорхойлж, хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг баримтлах.

4. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 474 дүгээр “Нийтийн аж ахуйн талаар авах зарим арга хэмжээний тухай”, 2021 оны 161 дүгээр “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл арга хэмжээг батлах тухай” тогтоолын хэрэгжилтийг үнэлж, аймаг, сумдын дулаан хангамж, ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг нэгдсэн удирдлагаар хангах үйл ажиллагааг холбогдох төрийн захиргааны төв байгууллагуудад хэрэгжилтийг бүрэн хангуулж ажиллуулах.

5. Улсын хэмжээнд Органик бохирдлын судалгааг ус хангамжийн худгуудад нарийвчлан хийх. Мөн төмөр, хар тугалга, уран нь хорт хавдар үүсгэдэг тул хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх байдлын судалгааг хийх.

6. Улсын хэмжээнд цэвэр, бохир усны лабораторийн техник, технологи, үйл ажиллагааны чадамжийг нэмэгдүүлэх.

7. Нийт сумдын 71 хувьд нь усны нөөц тогтоогдоогүй байна. Ундны усны баталгаат нөөцгүй байх нь сумын төвийн иргэдийн эрүүл мэнд, амьдралын чанарт нөлөөлж буй тул сумдын хөгжлийн бодлогод "усны нөөц тогтоох" зорилтыг заавал биелүүлэх шалгуур болгон тусгаж санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

8. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 53-р тогтоолоор УСУГ-тай гэрээтэй ус бохирдуулагч үйлдвэрүүдэд бага оврын урьдчилсан цэвэрлэх байгууламж барих ажлыг үүрэгжүүлсэн. Уг тогтоолын хэрэгжилт 15 хувьтай байгаа тул хэрэгжилтийг бүрэн хангуулах, хяналтыг сайжруулах шаардлагатай.

9. Нийслэл, аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг Усны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4-т заасан бүрэн эрхийн хүрээнд хот, суурины ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтийг үндэслэл болгон усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүс, ус хангамжийн эх үүсвэрийн тэжээгдлийн мужийн заагийг тогтоох ажлыг хангуулж ажиллуулах.

10. Улсын хэмжээнд тогтоогдсон байгаа нийслэл, аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор батлагдаж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн төвлөрсөн болон төвлөрсөн бус (худаг) ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн мэдээллийг газрын кадастрын нэгдсэн системд тогтмол бүртгэх ажлыг хангуулж ажиллуулах.

11. Орон нутгийн төрийн захиргааны төв байгууллагуудын хоорондын уялдаа холбоог хангуулж ажиллуулах. Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүсүүдэд ашиглах, эзэмших, өмчлөхөөр олгосон газрыг үе шаттайгаар чөлөөлөх ажлыг нийслэл, аймаг, сумдын Засаг дарга нарт үүрэг болгон хэрэгжүүлэх.



Ундны ус, ариун цэврийн байгууламжтай холбоотой хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд, тэдгээрийн үр нөлөө” /Тогтвортой хөгжлийн зорилт 6.1/



ЗӨВЛӨМЖ



Засгийн газарт /Ерөнхий сайдад/:

12. Аймаг, сумдын ЗДТГ нар, ус хангагч байгууллагуудад хяналт хийж илэрсэн зөрчлийг тогтмол арилгуулдаг байх. MNS 0900:2018 стандартын 6.3-д заасан “Төвлөрсөн ус хангамжийн усны чанар, аюулгүй байдлын хяналт шинжилгээ”-г 3-р хүснэгтийн дагуу хийж, эрүүл ахуйн дүгнэлт гаргах үйл ажиллагаа аймаг, сумдын түвшинд хангалтгүй байгаа нь хүн ам эрүүл, аюулгүй ундны усаар бүрэн хангуулах, ТХЗ 6.1 зорилт болон улсын хөгжлийн бодлогын зорилтыг хангуулж ажиллуулах.

13. Нийт сумдын 77 хувь нь цэвэрлэх байгууламжгүй. Цэвэрлэх байгууламж баригдсан ч цахилгаан, инженерийн шугам сүлжээнд холбогдоогүй байна. Иймд зураг төсөл хийгдэж, барилгын ажил явагдаж байгаа сумдад тэргүүн ээлжинд ашиглалтад оруулж, үе шаттайгаар бүх сумдыг дэд бүтцээр хангах ажлыг зохион байгуулах.



Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын сайдад

1. Дунд болон богино хугацааны бодлогын баримт бичгийг боловсруулахдаа хүн амыг эрүүл, аюулгүй ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах зорилго, зорилтын шалгуур үзүүлэлтийг хэмжигдэхүйц, зорилтот түвшнийг бодитой тодорхойлох.

2. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ундны ус, ариун цэврийн байгууламжтай холбоотой төсөл хөтөлбөрүүдийн үр дүнд гарч буй бодлогын хэрэгжилтийн эерэг өөрчлөлтийг үнэлэх.

3. Зөвхөн ариун цэврийн байгууламжийг сайжруулах биш, харин тэдгээрийг үр дүнтэй ашиглах, тогтвортой хөгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байгаад анхаарч нийт сумдыг төвлөрсөн системд холбох ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.



Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдад

1. Хүн амыг эрүүл, аюулгүй ундны усаар хангах нөөцийн эх үүсвэрийг бүрэн хамгаалалтад авах ажлыг зохион байгуулах.

2. Сумдын хүн амыг эрүүл, аюулгүй ундны усаар хангах усны нөөцийг тогтоох, хайгуулын ажлыг эрчимжүүлж, усны нэгдсэн мэдээллийн сангийн системийн ажлыг тогтмолжуулж, мэдээллийг бүрэн оруулж өгөгдлийн сан үүсгэж, газар олголтод ашиглах боломжийг бүрдүүлэх

3. Бэлчээрийг усжуулах зориулалтаар инженерийн хийцтэй худаг байгуулах, уст цэг тогтоох хайгуулын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх төлөвлөгөөг холбогдох хуульд нийцүүлэн боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

4. Бохирдуулагч ангиллын үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг баталгаажуулахдаа үйл ажиллагаанаас гарах хаягдал бохир усны бохирдлыг бууруулах урьдчилан цэвэрлэх байгууламж, тоног төхөөрөмж суурилуулсан эсэхэд тавих хяналтыг илүү сайжруулах.



Эрүүл мэндийн сайдад

1. Хүн амын ундны усны эх үүсвэр, бохир ус цэвэрлэх байгууламж дээр төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгуулах.

2. Улсын хэмжээнд Органик бохирдлын судалгааг ус хангамжийн худгуудад нарийвчлан хийх. Мөн Төмөр, хар тугалга, уран нь хорт хавдар үүсгэдэг тул хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх байдлын судалгааг хийх.



ЗӨВЛӨМЖ



Боловсролын сайдад:

1. Сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт ус, ариун цэврийн байгууламжийг зөв, зохистой ашиглах талаар үе шаттай мэдлэг олгох, зөв дадалд хэвшүүлэх талаар тусгах.



Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдад

1. Усны тухай хуулийн 16¹-р зүйлийн 16¹.4.14 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах.
2. БОУАӨЯ-ны сайдтай хамтран Усны тухай хуулийн 10 дугаар зүйлийн “10.1.3-д заасны дагуу инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглахтай холбоотой эрх зүйн баримт бичийг боловсруулан батлуулах. Мөн малчин өрхийн эрүүл аюулгүй ундны усаар хангах бодлогыг улсын хөгжлийн нэгдсэн бодлого болон ТХЗ 6.1-ын зорилттой уялдуулан боловсруулах.
3. MNS 6088:2010 “Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага” стандартад чанарын шаардлага хангасан өөрчлөлтүүдийг оруулж шинэчлэх.
4. Бохирдуулагч ангиллын үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч нарт төрийн захиргааны төв байгууллагаас үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохдоо үйл ажиллагаанаас гарах хаягдал бохир усны бохирдлыг бууруулах урьдчилан цэвэрлэх байгууламж, тоног төхөөрөмж суурилуулсан эсэхэд хяналтыг сайжруулах шаардлагатай.